

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/33/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас:261945 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор:М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Аудитор: Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	22
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	27
4.1 Ерөнхий зүйл	27
4.2 Материаллаг байдал.....	27
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	27
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	28
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	30
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	31
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	35
7. ОРОН НУТГИЙН ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ИЛРҮҮЛСЭН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:	57

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АӨСҮТ	Арьсны өвчин судлалын үндэсний төв
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
СХШҮДГ	Салбарын хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ЦССҮТ	Цус сэлбэлт судлалын үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭНЭҮТ	Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв
ЭСҮТ	Эмгэг судлалын үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Э.БАТШУГАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1136
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 92,462.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан нийт 1,531.1 сая төгрөгийн өртөгтэй 3 барилга байгууламжийг ашиглагч байгууллагад хууль тогтоомжийн дагуу шилжүүлээгүй;
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт арга хэмжээний данснаас 96.0 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан;
- Барьцаа дансны үлдэгдэлд бүртгэлтэй өмнөх онуудад хэрэгжиж дууссан 25 ажлын 67.5 сая төгрөгийн үлдэгдлийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид буцаан олгоогүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1,061.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хадгалалтын

гэрээ байгуулаагүй, агуулахад нь хадгалуулж байгаагаар жилийн эцэст тооцоо нийлсэн нь төсвийн хөрөнгө дутагдах эрсдэлтэй байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.5, 10 дугаар зүйлийн 10.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.6, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны "Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв байгуулах, дүрэм батлах тухай" 52 дугаар тогтоолоор Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын төвийн тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн лабораторийн тасгийг нэгтгэн Монгол Улсын хүн амын эрүүл мэнд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, хариу арга хэмжээ авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй "Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв"-ийг шинээр байгуулж, төвийн, дүрмийг баталж орон тооны дээд хязгаарыг 425 байхаар баталсан байна.

Импортын эмийг гаальд мэдүүлсэн үнээс эцсийн хэрэглэгчид очих хүртэлх бүх шатны үнэ болон үнийн өсөлтийг ил тод болгох <https://em.hdc.gov.mn/> цахим системийг гааль, татварын нэгдсэн системтэй холбож, Монгол Улсад бүртгэлтэй 2,234 нэр төрлийн эмийн үнийг газарзүйн байршлаар олон нийтэд нээлттэй болгож эмийн үнийн өөрчлөлт, өсөлтийг хянах боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,899.0 сая төгрөгийн Робот мэс заслын тоног төхөөрөмжийг ЭМС-ын А/482 дугаар тушаалаар Хавдар судлалын үндэсний төвд хүлээлгэн өгч, амжилттай нутагшуулснаар Монгол улсын анхны робот мэс заслыг 2025 оны 12 дугаар сард амжилттай гүйцэтгэж Монгол Улс "Робот мэс засал эмчилгээ"-г нэвтрүүлсэн дэлхийн 70 дахь улс болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 40 зорилтын хүрээнд 181 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг 73.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,064,989,812.6	784,687,559.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	97,184,101.2	51,358,801.7
33	АВЛАГА	215,512,632.4	160,482,736.6
34	УРЬДЧИЛГАА	27,939,059.9	21,450,474.2
35	БАРАА МАТЕРИАЛ	228,527,597.5	225,322,614.8
36	НӨӨЦИЙН БАРАА	9,506.1	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	495,816,915.5	326,072,932.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,856,362,683.0	2,097,175,241.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,856,362,683.0	2,097,175,241.0
39200	Биет хөрөнгө	1,792,320,533.8	2,032,729,088.1
39300	Биет бус хөрөнгө	64,042,149.2	64,446,153.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,921,352,495.6	2,881,862,800.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	261,960,508.8	236,117,713.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	261,960,508.8	236,117,713.8
41300	Өглөг	255,599,816.9	226,374,816.0
41400	Урьдчилж орсон орлого	6,360,691.9	9,742,897.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,659,391,986.8	2,645,745,086.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,659,391,986.8	2,645,745,086.8
51200	Хуримтлагдсан үр дүн	1,802,579,992.7	1,791,536,059.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,844,067.4	396,893,112.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,921,352,495.6	2,881,862,800.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,429,869,233.7	3,549,230,801.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	438,152,878.9	3,549,230,801.6
120	Нийтлэг татварын бус орлого	431,341,930.3	383,644,072.9
122	Тусламжийн орлого	6,810,948.5	3,165,557,828.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	28,900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,991,716,354.9	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,166,856,536.5	3,434,500,721.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,166,856,536.5	3,434,500,721.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,018,515,957.5	2,081,647,150.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	955,089,645.2	1,081,763,685.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,763,514.3	134,581,679.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,477,127.5	19,113,838.9
2104	Хангамж, бараа материалын зардал	108,973,797.2	51,228,173.2
2105	Нормативт зардал	490,141,022.4	493,213,466.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,665,753.2	27,461,951.3
2107	Томилолт, зочны зардал	7,509,238.1	6,952,076.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,070,456.6	28,103,737.9

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,825,403.0	239,228,542.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,148,340,578.9	1,352,853,570.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	263,012,697.3	114,730,080.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	80,002.0	63,523.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,576,966.7	112,828,045.7
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(85,496,964.7)	(112,764,522.5)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	177,515,732.6	1,965,557.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,481,428,908.5	2,481,428,908.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,842,106.9	5,842,106.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,487,271,015.4	2,487,271,015.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,626,716.3)	(5,626,716.3)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	211,695.1	211,695.1
7	Өмчид гарсан өөрчлөлт	20,260.0	20,260.0
9	Тайлант үеийн үр дүн	177,515,732.6	177,515,732.6
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,659,391,986.8	2,659,391,986.8
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,659,391,986.8	2,659,391,986.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(15,009,874.8)	(15,009,874.8)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,644,382,112.0	2,644,382,112.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	515,028.2	515,028.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(1,117,611.1)	(1,117,611.1)
19	Тайлант үеийн үр дүн	1,965,557.6	1,965,557.6
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,645,745,086.8	2,645,745,086.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,093,090,494.1	3,346,132,528.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,068,612.9	3,346,132,528.5
120	Нийтлэг татварын бус орлого	128,068,612.9	127,725,676.5
122	Тусламжийн орлого	-	3,218,377,952.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	28,900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,965,021,881.2	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,821,280,023.8	3,228,987,074.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,821,280,023.8	3,228,987,074.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,670,876,849.9	1,870,596,627.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,189,163.6	1,052,823,158.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,201,815.7	133,631,691.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,334,609.9	18,571,745.1

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	35,170,166.2	37,049,428.2
2105	Норматив зардал	404,804,858.3	496,160,010.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,468,199.6	34,922,996.7
2107	Томилолт, зочны зардал	7,312,726.6	6,957,461.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,121,899.3	27,528,527.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,273,410.6	62,951,608.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,150,403,173.9	1,358,390,447.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	271,810,470.3	117,145,454.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	242,750,431.6	162,146,917.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	242,750,431.6	162,146,917.8
2200	Дотоод эх үүсвэрээр	242,750,431.6	162,146,917.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(242,750,431.6)	(162,146,917.8)
14	Бусад эх үүсвэр	25,771.2	97,201.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(10,297.0)	(823,836.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	29,049,741.8	(45,825,299.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,134,359.5	97,184,101.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,184,101.2	51,358,801.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,719,834,704,500.00	1,625,753,755,104.04	94,080,949,395.96	94.5
12	Татварын бус орлого	1,719,834,704,500.00	1,625,753,755,104.04	94,080,949,395.96	94.5
120	Нийтлэг татварын бус орлого	7,894,589,800.00	11,739,647,359.01	(3,845,057,559.01)	148.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	7,738,606,100.00	11,473,239,717.82	(3,734,633,617.82)	148.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	155,983,700.00	266,407,641.19	(110,423,941.19)	170.8
122	Тусламжийн орлого	1,711,940,114,700.00	1,614,014,107,745.03	97,926,006,954.97	94.3
122005	Төсвөөс санхүүжих	1,711,940,114,700.00	1,614,014,107,745.03	97,926,006,954.97	94.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,719,834,704,500.00	1,621,945,395,384.57	97,889,309,115.43	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,573,927,504,500.00	1,524,047,125,025.07	49,880,379,474.93	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,133,686,600.00	189,040,602,727.69	43,093,083,872.31	81.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92,416,060,200.00	89,403,017,749.64	3,013,042,450.36	96.7
210101	Үндсэн цалин	39,498,347,000.00	38,163,678,247.31	1,334,668,752.69	96.6
210102	Нэмэгдэл	19,994,401,600.00	18,472,326,061.40	1,522,075,538.60	92.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,098,930,700.00	6,173,461,363.15	(1,074,530,663.15)	121.1
210104	Урамшуулал	5,291,806,700.00	5,460,040,082.97	(168,233,382.97)	103.2
210105	Гэрээт ажлын хөлс	22,532,574,200.00	21,133,511,994.81	1,399,062,205.19	93.8

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,802,460,600.00	11,345,750,326.56	456,710,273.44	96.1
210201	Тэтгэврийн даатгал	7,910,631,600.00	7,609,155,090.55	301,476,509.45	96.2
210202	Тэтгэмжийн даатгал	933,154,100.00	926,096,877.91	7,057,222.09	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	634,187,000.00	579,641,842.60	54,545,157.40	91.4
210204	Ажилгүйдлийн даатгал	464,902,500.00	449,315,323.41	15,587,176.59	96.6
210205	Эрүүл мэндийн даатгал	1,859,585,400.00	1,781,541,192.09	78,044,207.91	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,661,250,600.00	3,418,777,554.39	17,242,473,045.61	16.5
210301	Гэрэл, цахилгаан	1,065,082,200.00	814,213,487.62	250,868,712.38	76.4
210302	Түлш, халаалт	1,794,461,000.00	1,814,202,444.76	(19,741,444.76)	101.1
210303	Цэвэр, бохир ус	396,604,400.00	302,804,560.01	93,799,839.99	76.3
210304	Байрны түрээс	17,405,103,000.00	487,557,062.00	16,917,545,938.00	2.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,777,026,300.00	1,549,295,973.37	227,730,326.63	87.2
210401	Бичиг хэрэг	210,732,600.00	207,909,413.00	2,823,187.00	98.7
210402	Тээвэр, шатахуун	909,277,300.00	713,286,020.80	195,991,279.20	78.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	251,531,700.00	221,722,943.57	29,808,756.43	88.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	115,823,700.00	101,379,908.00	14,443,792.00	87.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	289,661,000.00	304,997,688.00	(15,336,688.00)	105.3
2105	Нормативт зардал	40,181,494,200.00	25,373,574,825.42	14,807,919,374.58	63.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,380,593,400.00	24,671,037,452.46	14,709,555,947.54	62.6
210502	Хоол, хүнс	619,826,700.00	552,380,572.96	67,446,127.04	89.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181,074,100.00	150,156,800.00	30,917,300.00	82.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,624,927,100.00	1,577,007,319.00	47,919,781.00	97.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	267,058,400.00	267,605,068.00	(546,668.00)	100.2
210602	Тавилга	2,541,000.00	2,541,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	124,793,500.00	76,552,860.00	48,240,640.00	61.3
210604	Урсгал засвар	1,230,534,200.00	1,230,308,391.00	225,809.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	954,621,500.00	829,564,055.00	125,057,445.00	86.9
210701	Гадаад албан томилолт	29,002,000.00	29,002,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	925,619,500.00	800,562,055.00	125,057,445.00	86.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,690,807,300.00	1,613,087,681.96	1,077,719,618.04	59.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,180,208,900.00	1,178,102,767.58	1,002,106,132.42	54.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	52,978,400.00	40,649,562.44	12,328,837.56	76.7
210803	Даатгалын үйлчилгээ	48,437,300.00	39,083,434.00	9,353,866.00	80.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	16,402,300.00	13,733,124.00	2,669,176.00	83.7

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,502,000.00	2,206,700.00	2,295,300.00	49.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	276,603,200.00	250,022,900.44	26,580,299.56	90.4
210807	Газрын төлбөр	28,146,000.00	25,904,515.00	2,241,485.00	92.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,729,900.00	229,839.00	1,500,061.00	13.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	81,799,300.00	63,154,839.50	18,644,460.50	77.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,025,038,800.00	53,930,527,242.35	6,094,511,557.65	89.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,067,343,900.00	51,996,694,333.78	6,070,649,566.22	89.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,957,694,900.00	1,933,832,908.57	23,861,991.43	98.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,341,793,817,900.00	1,335,006,522,297.38	6,787,295,602.62	99.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,273,860,194,700.00	1,273,860,194,700.00	-	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,273,779,015,500.00	1,273,779,015,500.00	-	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	81,179,200.00	81,179,200.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,933,623,200.00	61,146,327,597.38	6,787,295,602.62	90.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	170,520,000.00	170,520,000.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,965,427,300.00	3,388,802,821.32	576,624,478.68	85.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,606,595,300.00	30,411,911,078.10	4,194,684,221.90	87.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,103,859,000.00	27,095,874,147.96	2,007,984,852.04	93.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	87,221,600.00	79,219,550.00	8,002,050.00	90.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,907,200,000.00	97,898,270,359.50	48,008,929,640.50	67.1
220001	Барилга байгууламж	103,542,200,000.00	69,240,377,828.00	34,301,822,172.00	66.9
221001	Их засвар	17,591,900,000.00	14,816,076,629.00	2,775,823,371.00	84.2
222001	Тоног төхөөрөмж	24,773,100,000.00	13,841,815,902.50	10,931,284,097.50	55.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	3,808,359,719.47	(3,808,359,719.47)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(3,808,359,719.47)	3,808,359,719.47	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(3,808,359,719.47)	3,808,359,719.47	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,197,085.00	(2,197,085.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	10,460.00	238,433.00	(227,973.00)	2,279.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	49.00	51.00	(2.00)	104.1
610001	Төсвийн байгууллага	49.00	51.00	(2.00)	104.1

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4,293.00	4,284.00	9.00	99.8
620001	Удирдах ажилтан	79.00	84.00	(5.00)	106.3
620002	Гүйцэтгэх ажилтан	1,774.00	1,753.00	21.00	98.8
620003	Үйлчлэх ажилтан	399.00	400.00	(1.00)	100.3
620004	Гэрээт ажилтан	2,041.00	2,047.00	(6.00)	100.3
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	229,256.00	(229,256.00)	-
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	-	27,499.00	(27,499.00)	-
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	-	201,757.00	(201,757.00)	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,293.00	4,284.00	9.00	99.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	661.00	627.00	34.00	94.9
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	44.00	44.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2,872.00	2,958.00	(86.00)	103.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	574.00	565.00	9.00	98.4
650010	Гэрээт ажилтан	-	6.00	(6.00)	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	5.00	(3.00)	250.0
650013	Шатлалгүй цалин	-	7.00	(7.00)	-
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	140.00	72.00	68.00	51.4
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1,825.00	558.00	1,267.00	30.6
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1,096.00	533.00	563.00	48.6
660003	Эрүүл мэндийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч	729.00	25.00	704.00	3.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	41,777,538,382.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,777,538,382.91
122	Тусламжийн орлого	41,777,538,382.91
1221	Хандив тусламж /дотоод/	41,777,538,382.91
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,777,538,382.91
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,356,152,786.35
350012	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан,ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1,262,651,007.50
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,130,035,396.60
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,740,333,671.22

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,296,285,967.27
350017	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	6,992,079,553.97
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,275,135,576.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,196,635,576.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,771,719,333.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,551,568,029.21
210101	Үндсэн цалин	3,442,618,417.96
210102	Нэмэгдэл	3,346,535,399.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	136,532,804.30
210104	Урамшуулал	625,277,282.03
210105	Гэрээт ажлын хөлс	604,125.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	780,016,940.98
210201	Тэтгэврийн даатгал	574,993,184.83
210202	Тэтгэмжийн даатгал	45,751,078.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,459,346.97
210204	Ажилгүйдлийн даатгал	25,378,423.81
210205	Эрүүл мэндийн даатгал	104,434,907.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,380,263.13
210301	Гэрэл, цахилгаан	16,976,088.10
210302	Түлш, халаалт	6,444,588.19
210303	Цэвэр, бохир ус	11,478,656.84
210304	Байрны түрээс	97,480,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,106,054,912.32
210401	Бичиг хэрэг	169,727,943.90
210402	Тээвэр, шатахуун	516,370,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,569,089.37
210404	Ном, хэвлэл	20,995,930.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,477,131.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	245,914,138.00
2105	Нормативт зардал	2,533,635,526.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,824,982,380.10
210502	Хоол, хүнс	567,542,196.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	141,110,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,243,646,471.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,504,856,982.00
210602	Тавилга	176,135,972.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,492,100.00
210604	Урсгал засвар	555,161,417.30
2107	Томилолт, зочны зардал	1,595,074,176.00
210702	Дотоод албан томилолт	1,595,008,916.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	65,260.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,889,625,173.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,682,369,720.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,272,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,936,453.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,398,078.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	117,920,890.00
210807	Газрын төлбөр	6,435,031.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	55,218,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,939,717,841.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,305,512,591.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,634,205,249.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,424,916,243.02

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,424,916,243.02
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,234,265.78
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,306,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,369,375,977.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	78,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	70,500,000.00
223001	Бусад хөрөнгө	8,000,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,502,402,806.24
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,502,402,806.24)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,502,402,806.24)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,787,690.04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	174,955,910.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Эрүүл мэндийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт хүргэж, амьдралын чанарыг нь сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх салбарын оновчтой, чадварлаг бүтцийг бүрдүүлж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;
- Нээлттэй, ил тод, шуурхай үйлчилгээ үзүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн яам нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн салбарын бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус ерөнхийлөн захирагчийн салбарын хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь тайлант онд дотоод аудитын чиглэлээр 45 арга хэмжээнд хяналт шалгалт хийх удирдамжийг тус тус батлуулан, Төлөвлөгөөт 24, төлөвлөгөөт бус 8 нийт 32 арга хэмжээнд дотоод аудитыг хийж гүйцэтгэн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 74 зөвлөмж

өгч, 1 албан тушаалтанд хариуцлага тооцож, 5 байгууллагыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

Тус салбарын мөрдөж байгаа Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/590 дугаар тушаалаар баталсан НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний бүртгэлийн талаар тусгахаар шинэчлэн боловсруулалт хийгдэж байна

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилт төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтай холбоотой нэгдсэн журам, заавар аргачлалыг боловсруулаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,489.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 51,358.8 сая төгрөг болж, өмнөх оноос 45,825.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	10.9	4.7	(6.2)
Төгрөг	10.9	4.7	(6.2)
Банканд байгаа бэлэн мөнгө	97,164.8	51,349.3	(45,815.5)
Төгрөг	92,487.4	39,757.9	(52,729.5)
Төрийн сангийн харилцах	92,391.7	39,752.5	(52,639.2)
Арилжааны банк дахь харилцах	28.0	5.4	(22.7)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	67.6	-	(67.6)
Гадаад валют	4,677.4	11,591.4	6,914.0
Төрийн сангийн харилцах	162.2	-	(162.2)
Арилжааны банк дахь харилцах	4,515.2	11,591.4	7,076.2
Замд яваа мөнгөн хөрөнгө	8.4	4.8	(3.6)
Дүн	97,184.1	51,358.8	(45,825.3)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Нийт мөнгөн хөрөнгийн 77.4 хувь буюу 39,752.5 сая төгрөгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна. Үүнээс гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжиж байгаа 380 эрүүл мэндийн байгууллагын төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансны үлдэгдэл 33,408.3 сая төгрөг, улсын төсөв болон гүйцэтгэлээр санхүүждэг нийт 6 байгууллагын нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 174.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн техник хяналтын дансны үлдэгдэл 463.0 сая төгрөг, барьцаа дансны үлдэгдэлд 5,706.3 сая төгрөг байна.

Касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдэлд Монгол солонгосын дорнын анагаах ухааны төв ТӨҮГ-ын 1.7 сая төгрөг, Хавдар судлалын үндэсний төвийн 3.0 сая төгрөг тус тус байршиж байна.

Арилжааны банкны төгрөгийн харилцахад Эрүүл мэндийн 7 байгууллагын 5.4 сая төгрөг, гадаад валютын харилцахад Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн Өр хөрвүүлэх хөтөлбөрийн хүрээнд 11,583.3 сая төгрөг, ЭМЯ-ны гадаад валютын хөрвүүлгийн дансанд оны эцэст Олон Улсын атомын энергийн агентлагаас Хавдар судлалын үндэсний төвд хэрэгжүүлж эхэлсэн CRP судалгааны төслийн 8.1 сая төгрөг тус тус байршиж байна.

Уламжлалт анагаах ухааны төв 0.2 сая төгрөг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг 3.2 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төв 1.4 сая төгрөгийн замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 25,607.0 сая төгрөгийн зерчил илэрсэн байна. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,134.4 сая төгрөгийн ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн; / ХСҮТ 675.6 сая төгрөг, Баян-өлгий аймгийн Цэнгэл сумын эрүүл мэндийн төв 341.8 сая төгрөг, Хан-уул дүүргийн Туул тосгоны ЭМТ 337.2 сая төгрөг, Нийслэлийн Амгалан амаржих 128.1 сая төгрөг, Хан-уул дүүргийн ЭМТ 122.7 сая төгрөг, Сонгино хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг 187.0 сая төгрөг, ГССҮТ 82.9 сая төгрөг, Налайх дүүргийн ЭМТ 79.9 сая төгрөг, НЭМҮТ 48.1 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг 33.6 сая төгрөг, Завхан аймгийн Их-уул сумын ЭМТ 32.8 сая төгрөг, Говь-алтай аймгийн ЭМГ 31.0 сая төгрөг, Говь-алтай аймгийн Дарив сумын ЭМТ 21.1 сая төгрөг, Архангай аймгийн Өгийнуур сумын ЭМТ 12.6 сая төгрөг/
- Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээс шалтгаалан төсвөөс 128.3 сая төгрөгийн нөхөн олговор олгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй; /Чингэлтэй дүүргийн ЭМТ 52.6 сая төгрөг, Нийслэлийн Өргөө амаржих 36.8 сая төгрөг, төгрөг, Хавдар судлалын үндэсний төв 19.4 сая төгрөг, Баянгол дүүргийн ЭМТ 10.0 сая төгрөг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв 9.5 сая/
- Үйл ажиллагааны орлого болон түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн; /Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг 74.6 сая төгрөг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 51.8 сая төгрөг, Нийслэлийн Амгалан амаржих 17.1 сая төгрөг, Ховд аймгийн БОЭТ 10.5 сая төгрөг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв 8.1 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн сайхан сумын Номгон ЭМТ 6.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЭМТ 4.0 сая төгрөг, Улсын гуравдугаар төв эмнэлэг 3.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ЭМТ 1.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ЭМТ 1.0 сая төгрөг/
- Тусгай зөвшөөрөлгүй компаниас эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан; /Нийслэлийн Энэрэл эмнэлэг 650.7 сая төгрөг, Нийслэлийн Амгалан амаржих 296.6 сая төгрөг, Багануур дүүргийн ЭМТ 228.6 сая төгрөг, Ховд аймгийн ЭМГ 15.0 сая төгрөг/
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 2.242.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авч, гэрээг дүгнээгүй байна.
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан; /Эрүүл мэндийн хөгжлийн төв 73.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЭМТ 50.8 сая төгрөг, Ховд аймгийн ЭМГ 28.5 сая төгрөг, Ховд аймгийн БОЭТ 11.3 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын ЭМТ 2.2 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг 1.6 сая төгрөг/
- Тээвэр шатахууны тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй; /Баян-өлгий аймгийн Цэнгэл сумын ЭМТ 341.8 сая төгрөг, Ховд аймгийн БОЭТ 290.8 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг 76.0 сая төгрөг, Говь-алтай аймгийн Цогт сумын ЭМТ 48.0 сая төгрөг, Ховд аймгийн Дөргөн сумын ЭМТ 28.6 сая төгрөг, Хан-уул

дүүргийн Туул тосгоны ЭМТ 20.6 сая төгрөг, Завхан аймгийн Идэр сумын ЭМТ 18.1 сая төгрөг, Архангай аймгийн Ихтамир сумын ЭМТ 11.4 сая төгрөг, Дархан-уул аймгийн Орхон сумын ЭМТ 11.4, Төв аймгийн Баянчандмань сумын ЭМТ 10.4 сая төгрөг/

- Зардлын эдийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан; /Сонгинохайрхан дүүргийн ЭМТ 445.7 сая төгрөг, Өмнөговь аймгийн БОЭТ 61.6 сая төгрөг, Ховд аймгийн Цэцэг сумын ЭМТ 42.5 сая төгрөг, Говь-алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг 31.1 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг 22.4 сая төгрөг, Говь-алтай аймгийн Бигэр сумын ЭМТ 13.7 сая төгрөгийн, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ЭМТ 11.4 сая төгрөг, Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлэг 10.2, Төв аймгийн Заамар сумын ЭМТ 12.2 сая төгрөг, Дархан-уул аймгийн ЭМГ 4.6 сая төгрөг/
- Балансын урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалттай давхардуулан олгосон; /ЭМЯ 22.4 сая төгрөг, ЭМХТ 21.7 сая төгрөг, ЦССҮТ 13.6 сая төгрөг, Өвөрхангай аймгийн БОЭТ 13.6 сая төгрөг, АӨСҮТ 12.0 сая төгрөг, ХӨСҮТ 11.5 сая төгрөг, НЭМҮТ 9.1 сая төгрөг, ЭСҮТ 4.4 сая төгрөг, Баянхонгор аймгийн ЗӨСТ 2.7 сая төгрөг, Булган аймгийн Хишиг-өндөр сумын ЭМТ 4.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Сээрэй сумын ЭМТ 3.1 сая төгрөг, Ховд аймгийн ЗӨСТ 2.5 сая төгрөг, Булган аймгийн Рашаант сумын ЭМТ 2.3 сая төгрөг, Ховд аймгийн Үенч сумын ЭМТ 2.1 сая төгрөг/
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн акт, дүгнэлтгүйгээр засвар, үйлчилгээний зардал гаргасан; /Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 40.6 сая төгрөг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв 11.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ЭМТ 7.4 сая төгрөг, Баянзүрх дүүргийн Гачуурт тосгоны Хүн эмнэлэг 6.3 сая төгрөг/
- Илүү цагийн нэмэгдэл хөлсийг холбогдох журамд заасан нормыг баримтлалгүй илүү тооцож олгосон; /НЭМҮТ 176.6 сая төгрөг, Баян-өлгий аймгийн Цэнгэл сумын ЭМТ 91.4 сая төгрөг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 46.6 сая төгрөг, ЭНЭҮТ-II 18.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЭМТ 32.6 сая төгрөг, Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг 25.5 сая төгрөг, Дорнод аймгийн Халхгол сумын ЭМТ 17.5 сая төгрөг, Ховд аймгийн Алтай сумын ЭМТ 15.5 сая төгрөг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг 6.3 сая төгрөг, Завхан аймгийн Яруу сумын ЭМТ 4.0 сая төгрөг, Булган аймгийн ЭМГ 3.7 сая төгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 160,482.7 сая төгрөг болж, өмнөх оноос 55,029.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	349.9	502.5	152.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	206,276.2	141,444.4	(64,831.8)
Татаас, санхүүжилтийн авлага	2,934.0	6,110.9	3,176.9
Байгууллагаас авах авлага	5,458.1	11,863.4	6,405.4
Хувь хүмүүсээс авах авлага	494.4	561.5	67.0
Дүн	215,512.6	160,482.7	(55,029.9)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын үлдэгдэл буурахад Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага 64,831.8 сая төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 6,405.4 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Төлбөрт үйлчилгээний авлага дансанд Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох тусламж үйлчилгээний 141,444.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Тухайлбал: Хавдар судлалын үндэсний төв 23,773.2 сая төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төв 9,034.4 сая төгрөг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв 7,461.5 сая төгрөг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг 6,483.7 сая төгрөг, Улсын гуравдугаар төв эмнэлэг 2,975.1 сая төгрөг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 2,765.7 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төв 2,073.9 сая төгрөг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв 1,327.4 сая төгрөг, Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагууд 26,686.2 сая төгрөг, аймгийн эрүүл мэндийн байгууллагууд 58,863.3 сая төгрөг.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэлд эрүүл мэндийн 141 байгууллагын 6,729.9 сая төгрөгийн авлага, Глобал сангийн дэмждэгтэй дох сүрьеэгийн төслийн 8,277.9 сая төгрөгийн импортоор авах эмийн авлага тус тус бүртгэлтэй байна. Үүнээс: 0-1 жилийн насжилттай 114 эрүүл мэндийн байгууллагын 11,351.5 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 22 эрүүл мэндийн байгууллагын 375.7 сая төгрөг, 3-аас дээш жилийн насжилттай 10 эрүүл мэндийн байгууллагын 54.4 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой 1,474.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Харилцагч байгууллагатай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /Улсын хоёрдугаар төв эмнэлэг 396.5 сая төгрөг, Орхон аймгийн БОЭТ 23.8 сая төгрөг, Нийслэлийн Өргөө амаржих 30.9 сая төгрөг, Говь-алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг 23.7 сая төгрөг, Нийслэлийн Энэрэл эмнэлэг 4.4 сая төгрөг, Говь-алтай аймгийн Дарив сумын ЭМТ 7.5 сая төгрөг, Төв аймгийн Баяндэлгэр сумын ЭМТ 1.1 сая төгрөг/
- Авлага барагдуулах ажлыг зохион байгуулаагүй; /Орхон аймгийн БОЭТ 23.8 сая төгрөг, Дорнод аймгийн Чойбалсан сумын ЭМТ 8.0 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Баянтал сумын ЭМТ 5.6 сая төгрөг, Дундговь аймгийн Өлзийт сумын ЭМТ 4.3 сая төгрөг, Сонгино хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг 5.4 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг 3.6 сая төгрөг/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 21,450.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,488.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	27,560.3	12,715.1	(14,845.2)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	68.0	4,484.0	4,415.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	299.6	4,236.5	3,936.9
Цалингийн урьдчилгаа	7.4	15.0	7.5
Томилолтын урьдчилгаа	3.7	-	(3.7)
Дүн	27,939.1	21,450.5	(6,488.6)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 21,450.5 сая төгрөг бүртгэлтэй байна. Тухайлбал: Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс вакцины худалдан авалттай холбоотой урьдчилгаа төлбөрт 2,743.5 сая төгрөг, элэгний Д вирусийн эмийн худалдан авалттай холбоотой урьдчилгаа төлбөрт 10,614.9 сая төгрөг, Хорт хавдрын эмийн худалдан авалттай холбоотой урьдчилгаа төлбөрт 944.9 сая төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сангаас хэрэгжих төсөл хөтөлбөрийн урьдчилгаа санхүүжилт 133.0 сая төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гадаад сургалтын зардлын урьдчилгаа санхүүжилт 332.6 сая төгрөг, Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр 1,357.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой 355.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв сургалт, үзлэгт 226.8 сая төгрөгийн урьдчилгаа олгож зарцуулалтын тайланг бэлтгэж тайлагнаагүй;
- Нийслэлийн эрүүл мэндийн газар он дамжсан 6.9 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв өмнөх онд “Индиа фарм” ХХК-д эмийн үнэд 96.6 сая төгрөгийн шилжүүлсэн бөгөөд тус компани нь эмийг одоог хүртэл нийлүүлээгүй, урьдчилгаа дансанд бүртгэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 225,322.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,865.0 САГ-2026/33/НА-СТА-ТЕЗ

сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Түүхий эд материал	144,050.0	136,241.9	(7,808.1)
Тусгай зориулалттай материал	20,230.6	19,313.6	(917.0)
Эм боох материал	123,819.4	116,928.3	(6,891.1)
Дуусаагүй үйлдвэрлэл	1,339.0	976.6	(362.4)
Бэлэн бүтээгдэхүүн	6,502.3	8,427.6	1,925.3
Хангамжийн материал	76,296.3	79,676.5	3,380.2
Бичиг хэргийн материал	1,495.7	1,406.5	(89.1)
Аж ахуйн материал	16,459.7	16,963.5	503.8
Сэлбэг хэрэгсэл	3,327.7	3,406.3	78.6
Түлш, шатах тослох материал	1,131.3	1,016.0	(115.3)
Барилгын засварын материал	2,896.0	1,457.9	(1,438.1)
Хүнсний материал	1,477.4	1,636.5	159.1
Бусад хангамжийн материал	49,508.6	53,465.4	3,956.8
Биологийн хөрөнгө	1.1	1.1	-
Мал амьтад	338.9	323.2	(15.7)
Дүн	228,187.6	225,322.6	(2,865.0)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 225,322.6 сая төгрөг болж өмнөх оноос 1.3 хувиар буурахад Халдварт өвчин судлалын үндэсний төв 6,442.4 сая төгрөг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв 2,643.7 сая төгрөг, Цус сэлбэлт судлалын үндэсний төв 2,514.4 сая төгрөг, Улсын гуравдугаар төв эмнэлэг 1,382.8 сая төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төв 853.8 сая төгрөг, Нийслэлийн Хүрээ амаржих газар 546.6 сая төгрөг, ХУД-ийн нэгдсэн эмнэлэг 395.8 сая төгрөг, Нийслэлийн түргэн тусламжийн төв 326.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Улсын нэгдүгээр төв эмнэлэг 7,830.7 сая төгрөг, Хавдар судлалын үндэсний төв 1,157.0 сая төгрөг, БЗД-ийн эрүүл мэндийн төв 806.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газар 610.3 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг 504.6 сая төгрөг, Ховд аймгийн эрүүл мэндийн газар 500.9 сая төгрөг, Хэнтий аймгийн эрүүл мэндийн газар 429.3 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд бараа материал худалдан авсан 550,907.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан 70,488.1 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн бүртгэсэн 33,027.9 сая төгрөг, бусад 74,764.1 сая төгрөг, нийт 729,187.2 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 561,033.5 сая төгрөг, шилжүүлсэн 91,266.3 сая төгрөг, бусад 80,101.8 сая төгрөг, нийт 732,401.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой 5,548.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв 224.6 сая төгрөгийн бараа материалыг Сонгино хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгсөн боловч данс бүртгэлээс хасаагүй;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 94.8 сая төгрөгийн бараа материал хүлээлцсэн актгүй, орлогод бүртгэлгүй шууд зарлагдсан;
- Тайлант онд бараа материалын тайлан бэлтгээгүй; /Баян-өлгий аймгийн ЗӨСТ 61.3 сая төгрөг, Ховд аймгийн Дөргөн сумын ЭМТ 21.9 сая төгрөг/
- Жилийн эцэст бараа материалын тооллого хийгээгүй; /Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЭМТ 61.1 сая төгрөг, Дорнод аймгийн Булган сумын ЭМТ 44.4 сая төгрөг/
- Хугацаа дууссан эмнэлгийн хэрэгсэл болон цаашид ашиглах боломжгүй бараа материалыг акталж устгах арга хэмжээ аваагүй; /Улсын нэгдүгээр төв эмнэлэг 289.2 сая төгрөг, Баян-

өлгийн аймгийн Ногооннуур сумын ЭМТ 97.5 сая төгрөг, Архангай аймгийн Тариат сумын ЭМТ 55.5 сая төгрөг, Баянхонгор аймгийн Хонгор сумын ЭМТ 31.6 сая төгрөг, Архан хангай аймгийн Эрдэнмандал сумын ЭМТ 10.4 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЭМТ 6.1 сая төгрөг/

- Бараа материалын биет хяналтын тооллогоор 684.5 сая төгрөгийн бараа материал дутагдсан; /Халдварт өвчин судлалын үндэсний төв 619.8 сая төгрөг, Ховд аймгийн ЭМГ 56.9 сая төгрөг, Булган аймгийн Бугат сумын ЭМТ 7.8 сая төгрөг/
- Хэрэгцээ, шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэсэн; /Нийслэлийн түргэн тусламжийн төв 242.3 сая төгрөг, Сонгино хайрхан дүүргийн ЭМТ 151.2 сая төгрөг, ЭХЭМҮТ 41.8 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Шивээговь сумын ЭМТ 27.3 сая төгрөг, Дорноговь аймгийн ЭМГ 12.7 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ЭМГ 8.0 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Сант сумын ЭМТ 3.0 сая төгрөг/
- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн; /Хүүхдийн төв сувилал 17.0 сая төгрөг, ЭНЭҮТ-II 14.8 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ЭМТ 8.6 сая төгрөг, Баянзүрх дүүргийн Гачуурт тосгоны Хүн эмнэлэг 6.0 сая төгрөг/

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 9.5 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон байна.

Хүснэгт 5. Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Барааны нөөц	0.2	-	(0.2)
Бусад нөөц	9.3	-	(9.3)
Дүн	9.5	-	(9.5)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан
Нөөцийн бараа материалын дансны үлдэгдэл 9.5 сая төгрөгөөр буурахад бараа материалын данс хооронд шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 326,072.9 сая төгрөг болж, өмнөх оноос 169,744.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	495,816.9	326,072.9	(169,744.0)
Дүн	495,816.9	326,072.9	(169,744.0)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 169,744.0 сая төгрөгөөр буурахад улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар бэлтгэсэн барилга байгууламж, их завсар, тоног төхөөрөмж 175,951.6 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМС-ын 2025 оны тушаалуудаар харьяа байгууллагад шилжүүлэн өгсөн 345,695.6 сая төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн байна.

Эрүүл мэндийн яамны бусад эргэлтийн хөрөнгө дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалт болон олон улсын хандив тусламжаар бэлтгэсэн, эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлэх 326,072.9 сая төгрөгийн барилга, их засвар, 2,184.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,097,175.2 сая төгрөг болж, өмнөх оноос 240,812.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,792,320.5	2,032,729.1	240,408.6
Барилга, байгууламж, орон сууц	1,122,284.0	1,282,991.9	160,707.9
Авто-тээврийн хэрэгсэл	82,936.7	85,537.4	2,600.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	523,876.6	593,318.8	69,442.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	37,496.8	41,546.7	4,049.9
Зам, гүүрийн байгууламж	1,483.1	1,354.3	(128.9)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	27.6	27.6	-
Бусад үндсэн хөрөнгө	11,281.2	16,143.8	4,862.6
Дуусаагүй барилга, байгууламж	12,814.4	11,687.7	(1,126.7)
Ном	120.1	121.0	0.9
Биет бус хөрөнгө	64,042.1	64,446.2	404.0
Программ хангамж	7,214.8	6,271.5	(943.2)
Бусад биет бус хөрөнгө	56,827.4	58,174.6	1,347.2
Нийт дүн	1,856,362.7	2,097,175.2	240,812.6

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 38,262.7 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 324,040.6 сая төгрөг, шилжүүлэн авсан 31,574.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 35,840.4 сая төгрөг, шинээр үнэлж орлого авсан 26,852.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 40,023.9 сая төгрөг, худалдсан 1,194.7 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 10,077.7 сая төгрөг, дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсан 81,066.5 сая төгрөг, бусад 6,805.8 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна. Тайлант онд 208,242.7 сая төгрөгөөр элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 12,745.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь ЭМС-ын тушаалаар 1,281.0 сая төгрөгийн хүчилтөрөгчийн үйлдвэр, тоног төхөөрөмжийг хүлээн авсан боловч ашиглалтад оруулаагүй байна;
- Баянзүрх дүүргийн Хонхор тосгоны ЭМТ-ийн үндсэн хөрөнгийн дансанд 2015 онд ашиглалтад орсон 541.6 сая төгрөгийн өртөгтэй барилга дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна;
- Нийслэлийн Өргөө амаржих газар хандиваар ирсэн 42.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгээгүй;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцоолсон; /Ховд аймгийн Буянт сумын ЭМТ 434.8 сая төгрөг, Ховд аймгийн Чандмань сумын ЭМТ 17.0 сая төгрөг, Архангай аймгийн Хотонт сумын ЭМТ 12.6 сая төгрөг, Архангай аймгийн Цахир сумын ЭМТ 3.7 сая төгрөг/
- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй; /Завхан аймгийн Дөрвөлжин сумын ЭМТ 878.0 сая төгрөг, Төв аймгийн Баяндэлгэр сумын ЭМТ 779.5 сая төгрөг, Завхан аймгийн Идэр сумын ЭМТ 544.4 сая төгрөг, Завхан аймгийн Тэс сумын ЭМТ 587.8 сая төгрөг/

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 236,117.7 сая төгрөг болж, өмнөх оноос 25,842.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Өглөг	106,248.2	148,742.9	42,494.7
Ажилчидтай холбогдсон өглөг	29,652.6	61,099.9	31,447.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	75,507.2	87,561.5	12,054.3
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	1,076.5	-	(1,076.5)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	11.8	81.5	69.7
Бусад өглөг	149,351.7	77,631.9	(71,719.7)
Байгууллагад төлөх өглөг	148,927.0	76,674.3	(72,252.7)

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хувь хүмүүст төлөх өглөг	424.7	957.6	533.0
Урьдчилж орсон орлого	6,360.7	9,742.9	3,382.2
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,058.1	775.2	(282.9)
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	32.9	38.1	5.2
Бусад урьдчилж орсон орлого	5,269.7	8,929.6	3,659.9
Дүн	261,960.5	236,117.7	(25,842.8)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 25,842.8 сая төгрөг буюу 9.9 хувиар буурахад ажилчидтай холбоотой өглөг 31,447.3 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 12,054.3 сая төгрөг, урьдчилж орсон орлого 3,382.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж байгууллагад өгөх өглөг 72,252.7 сая төгрөгөөр хасагдсан нь голлон нөлөөлсөн байна.

Өглөгийн дансны үлдэгдлийн 26.9 хувь буюу 61,099.9 сая төгрөгийг эрүүл мэндийн ажилчидтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 38.7 хувь буюу 87,561.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлын өглөг, 33.8 хувь буюу 76,674.3 сая төгрөгийг байгууллагад төлөх өглөг, 0.6 хувь буюу 1,039.6 сая төгрөгийг бусад өглөг эзэлж байна.

Урьдчилж орсон орлогын дансны үлдэгдэлд 9,742.9 сая төгрөг бүртгэлтэй байна.Тухайлбал: Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төсөлд гадаад улсаас санхүүжүүлсэн өр хөрвүүлэх хөтөлбөрийн урьдчилгаанд 8,726.7 сая төгрөг, Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн дансанд 29 эрүүл мэндийн байгууллагын нэг эх үүсвэрээс худалдаж авах хавдрын эмийн урьдчилгаанд төлсөн 1,058.9 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөрийн данстай холбоотой 24,682.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /Улсын хоёрдугаар төв эмнэлэг 5,744.0 сая төгрөг, Эмгэг судлалын үндэсний төв 510.6 сая төгрөг, Хавдар судлалын үндэсний төв 4,129.6 сая төгрөг, Нийслэлийн эрүүл мэндийн газар 307.2 сая төгрөг, Нийслэлийн уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв 77.6 сая төгрөг, Говь-алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг 28.3 сая төгрөг, Говь-алтай аймгийн Дарив сумын ЭМТ 12.7 сая төгрөг, Нийслэлийн өргөө амаржих 12.5 сая төгрөг, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЭМТ 5.0 сая төгрөг/
- Дархан-уул аймгийн Нэгдсэн эмнэлэг 149.8 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй;

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

- Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлыг хүрээний 393 байгууллага үйл ажиллагаандаа нийт 17,728.6 сая төгрөгийн өртөгтэй программ хангамж, лицензийг ашигладаг бөгөөд тайлант онд нэмэлт хөгжүүлэлтийн төлбөрт урсгал зардлаас 732.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын төсвөөс 28.9 сая төгрөг, нийт 760.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,645,745.1 сая төгрөг болж, өмнөх оноос 13,646.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	457,967.9	457,315.9	(652.0)
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	352,303.3	351,685.4	(617.9)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	105,664.6	105,630.5	(34.1)
Хуримтлагдсан үр дүн	1,802,580.0	1,791,536.1	(11,043.9)

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өмнөх үеийн үр дүн	1,625,064.3	1,789,570.5	164,506.2
Тайлант үеийн үр дүн	177,515.7	1,965.6	(175,550.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,844.1	396,893.1	(1,951.0)
Засгийн газрын хувь оролцооны дүн	2,659,392.0	2,645,745.1	(13,646.9)

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,646.9 сая төгрөгөөр буурахад тайлант үеийн үр дүн голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүждэг 49 байгууллагын санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,324,748.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,068.4 сая төгрөг бүрдүүлж, нийт зарлагыг 3,331,817.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөлд өгсөн саналаас нийт зардлыг 1,484,394.9 сая төгрөгөөр бууруулж, урсгал зардлыг 1,654,327.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 193,095.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,847,422.9 сая төгрөгөөр анх баталсан байна.

Төсвийн тодотголоор урсгал зардлыг 80,399.8 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 47,188.4 сая төгрөг, нийт 127,588.2 сая төгрөгөөр бууруулж, нийт эх үүсвэрийг 1,719,834.7 сая төгрөгөөр, урсгал зардлыг 1,573,927.5 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 145,907.2 сая төгрөг, нийт зардлыг 1,719,834.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,711,940.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 7,894.6 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,614,014.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 11,739.6 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,621,945.4 сая төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 97,889.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл тийн хувь
71601	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	92,740.4	84,133.1	8,607.3	90.7
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,353,800.2	1,335,981.1	17,819.1	98.7
71603	Эрүүл мэндийн бодлого удирдлага	273,294.1	201,831.2	71,462.9	73.9
	Дүн	1,719,834.7	1,621,945.4	97,889.3	94.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгааны үр дүнгийн талаар:

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийт 445 байгууллагын орон тоо 30,328 байсан бөгөөд Засгийн газрын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах чиглэлийн хүрээнд эмч, сувилагчаас бусад орон тоог 1,066- аар бууруулсан. Үүнд: удирдах албан тушаалтнаас 85, гүйцэтгэх албан тушаалтнаас 978 орон тоог тус тус цомхотгосон байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны үр дүнгийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь ажлын нэг өдрийн хоолны зардлыг 1,000-10,000 төгрөгөөр 354 байгууллага, 11,000-20,000 төгрөгөөр 36 байгууллага, 23,000-37,000 төгрөгөөр 6 байгууллага, унааны зардлыг 500-15,000 төгрөгөөр тус тус тогтоож, тайлант хугацаанд хоолны зардалд 53,800.5 сая төгрөг, унааны зардалд 6,851.4 сая төгрөг, нийт 60,651.9 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр хоолны зардалд 45,619.7 сая төгрөг, унааны зардалд 5,116.6 сая төгрөг, нийт 50,736.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад томилолтын, арга хэмжээний судалгааны үр дүнгийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага гадаад томилолтын 32 арга хэмжээнд зориулж 545.7 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 41 арга хэмжээнд 609.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс эрх бүхий этгээдээс баталсан тушаал шийдвэргүй 2 арга хэмжээнд зориулж 41.3 сая төгрөгийн гадаад томилолтын зардал гарсан байна.

Төрд үчирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны үр дүнгийн талаар:

Удирдлагын буруу шийдвэрээр 2016-2025 онуудад ажлаас халагдсан нийт 15 байгууллагын 24 албан тушаалтанд Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс 579.3 сая төгрөгийг олгосон бөгөөд тайлант онд 78.6 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, 28.0 сая төгрөгийг ХЗДХЯ-ны төсвөөс төлж, үлдэгдэл 472.7 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Сургалт семинар хурал зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 271 байгууллага тайлант онд 1339 сургалт семинар хурал зөвлөгөөнд зориулж 6,253.6 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1306 арга хэмжээнд зориулж 4,302.7 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс эрх бүхий байгууллагаас баталсан тушаал шийдвэргүй 11.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүнгийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 18 байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийт 267.9 сая төгрөгийн ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, гэрээний төлбөрт 251.6 сая төгрөгийн олгосон байна.

3.5.3 Худалдан авах ажиллагаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын 2025 оны бараа, ажил үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөнд 380,385.7 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тайлант онд 145,907.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, шилжих 30, шинэ 8 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд: барилга байгууламжийн 30 төсөл, арга хэмжээ 103,542.2 сая төгрөг, их засварын 8 төсөл арга хэмжээ 17,591.2 сая төгрөг, тоног төхөөрөмжийн 22 төсөл арга хэмжээ 24,773.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Тайлант онд нийт 48 төсөл, арга хэмжээнд 97,898.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

Худалдан авах ажиллагаатай холбоотой 18,921.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Халдвар судлалын үндэсний төв гэрээний үнийн дүнгээс нийт 1,663.0 сая төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн;
- Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж шууд худалдан авалт хийсэн; /Улсын нэгдүгээр төв эмнэлэг 5,827.3 сая төгрөг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг 3,821.5 сая төгрөг, Налайх дүүргийн ЭМТ 1,007.7 сая төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төв 763.4 сая төгрөг, СЭМУТ 418.8 сая төгрөг, ГССҮТ 285.1 сая төгрөг, Баян-өлгий аймгийн Дэлүүн сумын ЭМТ 104.8 сая төгрөг, Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг 380.6 сая төгрөг, Дорнод аймгийн Булган сумын ЭМТ 97.3 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын ЭМТ 82.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн БОЭТ 61.6 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын ЭМТ 59.5 сая төгрөг, Дорнод аймгийн Баян-уул сумын ЭМТ 68.3 сая төгрөг, Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг 55.6 сая төгрөг, Ховд аймгийн Цэцэг сум ЭМТ 35.6 сая төгрөг, Говь-алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ 30.4, Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлэг 16.8 сая төгрөг/

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн салбарын тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 3 хөтөлбөрийн 6 хүрэх үр дүнд 13 шалгуур үзүүлэлтийг баталжээ.

Хүснэгт 11. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

№	Хөтөлбөр	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	2025 он хүрсэн түвшин	
71601 Нийгмийн эрүүл мэнд								
30.1	30.1.1	Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, дархлаажуулалттай халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт /хүйсээр, бүсээр/	хувь	2023	96.5	96.9	96.3
			А вирус гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 2 дахь тунгийн хамралт	хувь	2023	95.6	95.9	96.7
			Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилгын 3 дахь тунгийн хамралт /хүйсээр, бүсээр/	хувь	2023	96.1	96.5	96.0
	30.1.2	Товлолт дархлаажуулалтад хүний папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлнэ.	Хүний папиллома вирусийн эсрэг тарилгад хамрагдах зорилтот бүлгийн хамралт	хувь	2023	-	75.0	54.5
	30.1.3	Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулна.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт	хувь	2023	61.9	62	72.0
			Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт	хувь	2023	79.1	80	85.9
Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт			хувь	2023	37.8	38	33.3	
71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ								
30.2	30.2.1	Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшнийг бууруулна.	Эхийн эндэгдлийн харьцаа /100,000 амьд төрөлтөд, бүсээр/	промилль	2023	26.4	25	31.4
			Нялхсын эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/	промилль	2023	12.3	12	13.6

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/	промилль	2023	14.9	14	16.9
	30.2.2	Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын тохиолдлыг бууруулна.	В вирус гепатит өвчний тохиолдлын түвшин /100,000 хүн амд ногдох, хүйсээр, бүсээр/	промилль	2023	3.6	2	2.0
71603 Эрүүл мэндийн бодлого, удирдлага								
	30.3	Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд үндэслэн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулж, иргэдэд ээлтэй болгоно.	Амбулаториор үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж	хувь	2023	83	85	86.0
			Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж	хувь	2023	92.1	95	88.0

Эрүүл мэндийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрөөс зарим үзүүлэлт зорилтод түшинд хүрээгүй байна. Тухайлбал: Хүний папилломо вирусын эсрэг тарилгад хамрагдах зорилтот бүлгийн хамралт 20.5 хувиар, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт 4.7 хувиар тус тус доогуур, Эхийн эндэгдлийн харьцаа /100,000 амьд төрөлтөд, бүсээр/ 6.4 хувиар, Нялхсын эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/ 1.6 хувиар, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/ 2.9 хувиар тус тус өссөн байна.

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 6,356.1 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 17,130.0 сая төгрөг, Олон улсын байгууллагаас төсөл хэрэгжүүлэх хүрээнд 1,262.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,740.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,296.3 сая төгрөг, ЭМДС-ийн нэмэлт орлого 6,992.1 сая төгрөг, нийт 41,777.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 39,196.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 78.5 сая төгрөг, нийт 39,275.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн салбарт гадаадын зээл тусламжаар 10 төсөл хэрэгжиж байгаагаас 5 төсөл хэрэгжиж дууссан, 5 төслийн хэрэгжүүлэгч нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 12. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

№	Төслийн нэр, дугаар	Зээл, тусламж	Хэрэгжих он	Нийт төсөв	Нийт зарцуулалт	Хэрэгжилтийн хувь
	I. АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК			735,741.1	263,445.6	
1		зээл	2020-2027	270,804.1	103,134.0	38.1

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл	тусламж		12,377.2	1,999.8	16.0
2	Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөл	зээл	2025-2029	292,357.5	-	-
3	Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төсөл L4068-МОН, L4069-МОН, L8399	зээл	2021-2025	142,266.4	142,121.7	99.0
4	Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах, эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх төсөл МОН-9218	тусламж	2021-2025	17,936.0	16,190.1	95.0
II. ЛЮКСЕМБУРГИЙН ЗАСГИЙН ГАЗАР				11,118.8	7,154.1	
5	Монгол Улсын Зүрх Судлал, Зүрхний мэс засал ба Телемедицин МОН/007	тусламж	2022-2027	11,118.8	7,154.1	64.0
III. ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК, ЛЮКСЕМБУРГИЙН ЗАСГИЙН ГАЗАР				128,654.9	-	
6	Зүрх судасны үндэсний төвийн бүтээн байгуулалт, өргөжилт, хөгжлийг дэмжих төсөл МОН/008	зээл	2026-2029	125,108.0	-	-
		тусламж		3,546.9	-	-
IV. ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК				174,503.3	-	-
7	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих төсөл	зээл	2024-2029	174,503.3	-	-
		тусламж				
V. ГЛОБАЛ САН				83,046.0	27,255.9	
8	"Монгол улсад ХДХВ/ДОХ, Сүрьеэгээс сэргийлэх, эмчилгээ үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх MNG-C-МОН	тусламж	2024-2026	83,046.0	27,255.9	32.8
VI. АВСТРИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР				41,690.8	41,690.8	
9	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах	зээл	2023-2025	41,690.8	41,690.8	100.0
VII. ДЭЛХИЙН БАНК				231,159.1	226,691.3	
10	Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл P173799	зээл	2020-2023	231,159.1	226,691.3	98.1

Жилийн эцсийн байдлаар 90.0 хувиас дээш хэрэгжилттэй 4 төсөл, 64 хувийн хэрэгжилттэй 1 төсөл, 50.0 хувиас доош хэрэгжилттэй 5 төсөл байна. Тухайлбал: Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж байгаа Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслөөс Нийслэлийн түргэн тусламжийн үндэсний төвийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдээгүй, үнэлгээний хороо байгуулагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах үе шатны ажлыг эхлүүлсэн байна.

Хан-уул дүүргийн нэгдсэн эмнэлэг барих төслийн барилга тоног төхөөрөмжийн гэрээний хэрэгжилт 29.0 хувьтай буюу ажил үргэлжилж байна.

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөл нь 2025 оны 2 дугаар сард

хэрэгжиж эхэлсэн бөгөөд тайлант онд зөвлөх үйлчилгээний ажлын сонгон шалгаруулалтыг хийж, гэрээг байгуулсан байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Люксембургийн засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа Зүрх судасны үндэсний төвийн бүтээн байгуулалт, өргөжилт, хөгжлийг дэмжих төслийн гэрээг 2025 оны 10 дугаар сард байгуулж төслийн нэгжийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл, тусламжаар хэрэгжиж байгаа “Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих төсөл”-ийн төслийн нэгжийг 2025 оны 10 дугаар сард сонгон шалгаруулж, Техник эдийн засгийн үндэслэл тооцооллийн судалгаа хийгдэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Б.Отгонцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 3/1471 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,166,856.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,668.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 267,644.2 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлттэй байгаа тул материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэх үе шатанд 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,547,328.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 35,473.3 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн

хэрэгжилттэй холбоотой 314.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 28 төсвийн шууд захирагчид 37.8 сая төгрөгийн 11 төлбөрийн акт, 211.5 сая төгрөгийн зөрчил арилгах 13 албан шаардлага, 64.8 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 314.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЭМТ байгууллагын даргын шийдвэргүй Солонгос ард улсад ажилчдыг шинжилгээний аялалд хамруулахад 50.8 сая төгрөгийг зарцуулсан;
- Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЭМТ Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 15.0 сая төгрөгийг "Хөх хотод" ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулахад зарцуулсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж, үр ашиггүй зарцуулсан; /ЭМЯ 37.3 сая төгрөг, УНТЭ 23.1 сая төгрөг, ХСҮТ 39.4, Нийслэлийн түргэн тусламжийн төв 16.3 сая төгрөг, Завхан аймгийн Тэс сумын ЭМТ 9.0 сая төгрөг, Дорнод аймгийн Матад ЭМТ 1.1 сая төгрөг/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн асуудлаар, нийт 142,723.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 109.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 76,484.7 сая төгрөгийн зөрчилд 137 албан шаардлага хүргүүлж, 28,205.6 сая төгрөгийн зөрчилд 89 зөвлөмж өгч, 37,924.4 сая төгрөгийн зөрчилд 12 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх СХШҮДГ харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүйгээс цахим хуудсанд орлого, зарлагын гүйлгээг дутуу мэдээлсэн 66,704.1 сая төгрөг, хугацаа хоцроож мэдээлсэн 40,654.5 сая төгрөг, бусад мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй 18,893.9 сая төгрөг зэрэг нийт 126,252.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 68,707.7 сая төгрөгийн зөрчилд 63 албан шаардлага хүргүүлж, 26,186.1 сая төгрөгийн 61 зөвлөмж өгч, 31,358.7 сая төгрөгийн хариуцлага тооцох 8 албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Албан шаардлага

1.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын харьяа Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн 15 эмнэл ТУЗ байгуулахаас 2025 оны байдлаар 8 эмнэлгийн ТУЗ-г байгуулаагүй, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зорилттой нийцээгүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс

томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23-д "Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар нээлттэй сонгон шалгаруулна", Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх заавар"-ын 1-т Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д эмнэлгийн засаглах эрхийг шилжүүлэх замаар шийдвэр гаргалт, тусламж үйлчилгээнд тавих хяналт, үйл ажиллагааны зохицуулалтад өмчлөгч болон санхүүжүүлэгч байгууллага, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцох боломжийг бүрдүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх зүйн орчинд нийцүүлэн ТУЗ байгуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2025 оны санхүүгийн тайланд орон нутгийн төрийн аудитын байгууллагуудын аудит хийсэн дүнгийн талаар:

2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,683.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 435.1 сая төгрөгийн зөрчилд 127 төлбөрийн акт тогтоож, 7,793.9 сая төгрөгийн зөрчилд 187 албан шаардлага хүргүүлж, 4,121.6 сая төгрөгийн зөрчилд 373 зөвлөмж өгч, 332.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 4 албан шаардлага өгсөн бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвийн өмч нь орон нутагт хамаардаг, ЭМДС-аас гүйцэтгэлээр болон хувьсах зардлаар санхүүжилт авдаг боловч өмчийн хэлбэр нь ББН байгаагаас удирдлагын менежмент, санхүүгийн хяналтыг тогтолцоо алдагдахад хүрсэн тул хууль, хяналт, эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 54.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна", Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.11-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах", 8.1.13-д "аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах", гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өрхийн эрүүл мэндийн төвийн өмчийн хэлбэр, удирдлагын менежмент, эрх зүйн орчинг тодорхой болгох албан шаардлага хүргүүллээ.

Зөвлөмж

1. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага өмнөх оноос 64,831.7

сая төгрөгөөр буурсан боловч ажилчидтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 34,447.3 сая төгрөгөөр, бараа, үйлчилгээний өглөг 12,054.2 сая төгрөгөөр тус тус өссөнөөс үзэхэд санхүүгийн удирдлагыг оновчтой, зохистой хэрэгжүүлээгүй, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтвортой байдал, сахилга бат, тогтолцоог сайжруулах шаардлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 14.2.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлж, ажилчидтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг бууруулах зөвлөмж өглөө.

2. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын давсан орлого сүүлийн 2 жилийн байдлаар 2024 онд 6 байгууллага 3,282.9 сая төгрөг, 2025 онд 10 байгууллага 3,786.6 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс давсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхгүй СС-ын тушаалаар эрх олгосны дагуу нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулахдаа орлого бууруулах бичилт хийснээр төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого бодит гүйцэтгэлээр тайлагнагдахгүй байгаа нь дараа жилийн орлогын төлөвлөгөөнд сөргөөр нөлөөлж байгаагаас шалтгаалан зарим байгууллага төлөвлөсөн орлогын 2024 онд 84.2 хувийг, 2025 онд 99.8 хувийн орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулж байна. Иймд төсвийн байгууллагын орлогыг бодит гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байх шаардлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 14.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлд суурилж бодитой төлөвлөж байх, давсан орлогоор нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон зарим хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 7 байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагуудад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 38,095.5 сая төгрөгийн 22 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн аудитаар дахин үнэлж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн:

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 275.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 61,401.3 сая төгрөгийн зөрчил арилгах 6 албан шаардлага, хариуцлага тооцох 2 албан шаардлага, 312.5 сая төгрөгийн зөрчлийг давтан

гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, 542.0 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэснээс хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 13.Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2.0	275.6	2.0	275.6	100.0
2	Албан шаардлага	6.0	61,401.3	6.0	61,401.3	100.0
3	Хариуцлага тооцох албан шаардлага	2.0	-	1.0	-	100.0
4	Зөвлөмж	3.0	312.5	2.0	-	66.7
Нийт дүн		13.0	61,989.4	11.0	61,676.9	91.7

Өмнөх оны аудитаар өгсөн 2 төлбөрийн акт, 6 албан шаардлага, 2 зөвлөмж, хариуцлага тооцох 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, биелэлт 91.7 хувийн биелэлттэй байна.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд төлөөлөн удирдах зөвлөл байгуулах талаар зөвлөмж өгсөн нь хэрэгжээгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн салбарын Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журамд зааснаар тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоож баталсан эсэх;

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын үндсэн цалингийн доод хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд тайлант онд цалин нэмэхтэй холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолоор эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг салбарын хамтын хэлэлцээр болон ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төсөвт багтаан нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн тул тогтоолын хэрэгжилтийг нарийвчлан шалгах;

Тус төсвийн ерөнхийлөн захирагч нь 450 төсвийн шууд захирагчийн тайланг шууд нэгтгэдэг тул цаашид төвлөрүүлэн захирагчтай болох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 149,360.5 сая төгрөгийн 687 алдаа¹ илэрснээс аудитын явцад 149,332.0 сая төгрөгийн 685 алдааг залруулж 28.6 сая төгрөгийн 2 алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд: Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 83,817.1 сая төгрөгийн 192 алдаа, буруу тусган илэрхийлсэн 65,514.9 сая төгрөгийн 493 алдааг залруулсан.

106	Баянзүрх дүүргийн Төгс жаргалан оточ ӨЭМТ	3	6.5	1	0.2	1	4.7	1	1.6	-	-	-	-
107	Баянгол дүүргийн Сан эго фамили ӨЭМТ	2	2.6	-	-	-	-	2	2.6	-	-	-	-
108	Сонгинохайрхан дүүргийн Анан ӨЭМТ	3	2.1	2	2.1	-	-	1	-	-	-	-	-
109	Сонгинохайрхан дүүргийн Ариун-Энэрэл ӨЭМТ	5	3.2	2	2.2	-	-	3	0.9	-	-	-	-
110	Сонгинохайрхан дүүргийн Батцэцэн ӨЭМТ	2	0.6	1	0.6	-	-	1	-	-	-	-	-
111	Сонгинохайрхан дүүргийн Баянбигэр ӨЭМТ	4	3.4	2	2.5	-	-	2	0.9	-	-	-	-
112	Сонгинохайрхан дүүргийн Гурван цүүр ӨЭМТ	3	0.9	1	0.8	-	-	2	0.1	-	-	-	-
113	Сонгинохайрхан дүүргийн Одонтманал ӨЭМТ	6	14.4	3	3.5	-	-	3	10.9	-	-	-	-
114	Сонгинохайрхан дүүргийн Отгон долоон бурхан ӨЭМТ	5	2.1	2	1.2	-	-	3	0.9	-	-	-	-
115	Сонгинохайрхан дүүргийн Өлзийт манал ӨЭМТ	4	6.5	2	6.5	-	-	2	-	-	-	-	-
116	Сонгинохайрхан дүүргийн ТОНЭ ӨЭМТ	2	0.7	1	0.7	-	-	1	-	-	-	-	-
117	Сонгинохайрхан дүүргийн Ээлтэй ӨЭМТ	5	2.2	2	1.7	-	-	3	0.5	-	-	-	-
118	Сонгинохайрхан дүүргийн Эхэн босго ӨЭМТ	3	16.6	1	6.0	2	10.6	-	-	-	-	-	-
119	Сонгинохайрхан дүүргийн Алтанцэгцүүхэй ӨЭМТ	1	1.6	-	-	1	1.6	-	-	-	-	-	-
120	Сонгинохайрхан дүүргийн Арвин мэнд ӨЭМТ	3	14.1	1	2.8	2	11.3	-	-	-	-	-	-
121	Сонгинохайрхан дүүргийн Байгальнаран ӨЭМТ	2	6.5	-	-	1	2.2	1	4.3	-	-	-	-
122	Сонгинохайрхан дүүргийн Наран манал ӨЭМТ	3	15.4	1	1.5	2	13.9	-	-	-	-	-	-
123	Сонгинохайрхан дүүргийн Энх-Элбэрэл ӨЭМТ	3	27.7	1	12.2	2	15.5	-	-	-	-	-	-
124	Сонгинохайрхан дүүргийн Буянтманал ӨЭМТ	2	80.4	-	-	-	-	2	80.4	-	-	-	-
125	Сонгинохайрхан дүүргийн Гурван тэрх ӨЭМТ	1	5.6	-	-	-	-	1	5.6	-	-	-	-
126	Сонгинохайрхан дүүргийн Гурванжаргал хайрхан ӨЭМТ	2	15.7	1	6.6	-	-	1	9.1	-	-	-	-
127	Сонгинохайрхан дүүргийн Жаргал Өлзий ӨЭМТ	2	111.1	-	-	-	-	2	111.1	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

128	Сонгинохайрхан дүүргийн Мичид ундрага ӨЭМТ	1	4.1	-	-	-	-	1	4.1	-	-	-	-
129	Сонгинохайрхан дүүргийн Санхум ӨЭМТ	1	1.0	-	-	-	-	1	1.0	-	-	-	-
130	Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ	1	5.7	-	-	-	-	1	5.7	-	-	-	-
131	Сонгинохайрхан дүүргийн Энхийн өргөө ӨЭМТ	3	95.5	-	-	-	-	3	95.5	-	-	-	-
132	Баянгол дүүргийн Аминжаргалан ӨЭМТ	2	27.4	-	-	2	27.4	-	-	-	-	-	-
133	Баянгол дүүргийн Ангирмаа ӨЭМТ	7	16.6	1	3.9	1	3.4	5	9.3	-	-	-	-
134	Баянгол дүүргийн Арвин хурд ӨЭМТ	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
135	Баянгол дүүргийн Ариун чанар ӨЭМТ	3	1.1	1	0.5	2	0.6	-	-	-	-	-	-
136	Баянгол дүүргийн Ашид амгалан ӨЭМТ	1	2.3	1	2.3	-	-	-	-	-	-	-	-
137	Баянгол дүүргийн Дэшиг дүн ӨЭМТ	2	0.3	1	0.3	1	-	-	-	-	-	-	-
138	Баянгол дүүргийн Илаарших ӨЭМТ	1	2.4	-	-	1	2.4	-	-	-	-	-	-
139	Баянгол дүүргийн Мөнгөлөнгоо ӨЭМТ	2	7.7	1	4.2	1	3.5	-	-	-	-	-	-
140	Баянгол дүүргийн Мөнх-Увидас ӨЭМТ	7	187.9	1	0.1	5	186.3	1	1.5	-	-	-	-
141	Баянгол дүүргийн Мэлмий хурц ӨЭМТ	3	6.2	2	1.9	1	4.3	-	-	-	-	-	-
142	Баянгол дүүргийн Сайн чагануур ӨЭМТ	2	1.6	1	0.5	1	1.1	-	-	-	-	-	-
143	Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ	4	58.3	1	0.7	2	57.6	1	-	-	-	-	-
144	Баянгол дүүргийн Усантүрүү ӨЭМТ	3	2.1	2	0.7	1	1.4	-	-	-	-	-	-
145	Баянгол дүүргийн Халпи доктор ӨЭМТ	4	7.7	1	0.5	1	3.5	2	3.7	-	-	-	-
146	Баянгол дүүргийн Чин гэгээ ӨЭМТ	3	13.6	1	0.1	1	13.4	1	-	-	-	-	-
147	Баянгол дүүргийн Шардэгд ӨЭМТ	7	11.8	1	0.1	3	7.4	3	4.3	-	-	-	-
148	Баянгол дүүргийн Энхт ӨЭМТ	2	24.7	-	-	1	24.7	1	-	-	-	-	-
149	Баянгол дүүргийн Эрхэмжаргалан ӨЭМТ	7	53.7	3	39.7	2	13.2	2	0.9	-	-	-	-
150	Сүхбаатар дүүргийн Ачит гар ӨЭМТ	4	11.2	1	0.2	-	-	3	11.0	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

151	Сүхбаатар дүүргийн Гэрэлт манал ӨЭМТ	5	17.0	1	0.2	1	9.2	3	7.6	-	-	-	-	-
152	Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ	4	67.2	-	-	-	-	4	67.2	-	-	-	-	-
153	Сүхбаатар дүүргийн Манай эмч ӨЭМТ	8	1,708.0	-	-	7	1,375.3	-	-	1.00	1.00	332.8	-	-
154	Сүхбаатар дүүргийн Өнөр өрх ӨЭМТ	6	64.1	1	8.5	1	32.9	4	22.7	-	-	-	-	-
155	Сүхбаатар дүүргийн Өөдрөг-Энх ӨЭМТ	8	478.3	1	1.8	7	476.5	-	-	-	-	-	-	-
156	Сүхбаатар дүүргийн Сайн наран ӨЭМТ	3	2.1	1	0.2	-	-	2	1.9	-	-	-	-	-
157	Сүхбаатар дүүргийн Санколл ӨЭМТ	4	35.3	1	5.0	3	30.3	-	-	-	-	-	-	-
158	Сүхбаатар дүүргийн Тэгшмэнд ӨЭМТ	2	3.0	-	-	-	-	2	3.0	-	-	-	-	-
159	Сүхбаатар дүүргийн Энхийн санаа ӨЭМТ	3	6.3	-	-	-	-	3	6.3	-	-	-	-	-
160	Сүхбаатар дүүргийн Увидаст-Од ӨЭМТ	5	16.5	1	0.2	-	-	4	16.3	-	-	-	-	-
161	Сүхбаатар дүүргийн Энх сүндэр ӨЭМТ	3	35.3	1	0.2	2	35.1	-	-	-	-	-	-	-
162	Сүхбаатар дүүргийн Энэр-Ази ӨЭМТ	3	7.4	-	-	-	-	3	7.4	-	-	-	-	-
163	Багануур дүүргийн Биваангирд ӨЭМТ	4	5.0	-	-	2	3.5	2	1.5	-	-	-	-	-
164	Багануур дүүргийн Энх-Өрх ӨЭМТ	2	0.2	-	-	-	-	2	0.2	-	-	-	-	-
165	Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ	3	6.0	-	-	-	-	3	6.0	-	-	-	-	-
166	Налайх дүүргийн Амь эрдэнэ ӨЭМТ	2	0.1	-	-	-	-	2	0.1	-	-	-	-	-
167	Налайх дүүргийн Ачлал Налайх ӨЭМТ	1	0.1	-	-	-	-	1	0.1	-	-	-	-	-
168	Налайх дүүргийн Нарны-Эрч ӨЭМТ	1	0.1	-	-	-	-	1	0.1	-	-	-	-	-
169	Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ	2	0.2	-	-	-	-	2	0.2	-	-	-	-	-
170	Чингэлтэй дүүргийн Гүсү Дэвү ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
171	Чингэлтэй дүүргийн Ижил санаа ӨЭМТ	4	61.4	-	-	2	56.4	2	5.0	-	-	-	-	-
172	Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ	5	16.0	1	3.3	1	10.0	3	2.7	-	-	-	-	-
173	Чингэлтэй дүүргийн Мөнхбаясгалант ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
174	Чингэлтэй дүүргийн Мэнд арвижих ӨЭМТ	4	46.3	1	3.4	1	43.0	2	-	-	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

175	Чингэлтэй дүүргийн Мэнд цолмон ӨЭМТ	2	3.5	-	-	-	-	2	3.5	-	-	-	-	-
176	Чингэлтэй дүүргийн Нандин хүсэл ӨЭМТ	3	40.7	-	-	1	40.7	2	-	-	-	-	-	-
177	Чингэлтэй дүүргийн Таны итгэл ӨЭМТ	4	45.7	-	-	2	42.2	2	3.5	-	-	-	-	-
178	Чингэлтэй дүүргийн Тэгш өлзий ӨЭМТ	4	39.8	-	-	1	-	3	39.8	-	-	-	-	-
179	Чингэлтэй дүүргийн Ундрах Ирээдүй ӨЭМТ	4	40.8	-	-	1	33.6	3	7.1	-	-	-	-	-
180	Чингэлтэй дүүргийн Үйлс нэгтэн ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
181	Чингэлтэй дүүргийн Цэнгэлжаргал Хайрхан ӨЭМТ	5	52.4	1	1.5	1	43.8	3	7.1	-	-	-	-	-
182	Чингэлтэй дүүргийн Чинхүслэн ӨЭМТ	5	23.2	-	-	2	22.3	3	0.9	-	-	-	-	-
183	Чингэлтэй дүүргийн Шэжиддүг ӨЭМТ	3	54.5	1	0.8	1	53.7	1	-	-	-	-	-	-
184	Чингэлтэй дүүргийн Энэрэнгүй сэтгэл ӨЭМТ	2	31.2	-	-	1	31.2	1	-	-	-	-	-	-
185	Чингэлтэй дүүргийн Энэрэнгүй үйлс ӨЭМТ	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-
Нийт дүн		561	6,855.8	120	427.1	148	4,254.5	289	1,841.4	4	4	332.8	-	-

7.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой															
1	Ховд аймгийн Баатархайрхан ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
2	Ховд аймгийн Булган сумын Булган ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	
3	Баянзүрх дүүргийн Оцело сэргэлт ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	
4	Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ	1	80.8	-	-	-	-	1	80.8	-	-	-	-	-	
5	Баянзүрх дүүргийн Сувилахуй ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	Баянзүрх дүүргийн Одот тэнгэр оршихуй ӨЭМТ	1	632.7	-	-	1	632.7	-	-	-	-	-	-
7	Баянзүрх дүүргийн Цэцэнэ бат амгалан ӨЭМТ	1	171.7	-	-	1	171.7	-	-	-	-	-	-
8	Хан-Уул дүүргийн Уясах ӨЭМТ	1	63.1	-	-	-	-	1	63.1	-	-	-	-
9	Хан-Уул дүүргийн Эрдэнэ энхсаран ӨЭМТ	1	153.9	-	-	-	-	1	153.9	-	-	-	-
10	Баянзүрх дүүргийн Тэгш дүүрэн хүслэн ӨЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
11	Баянзүрх дүүргийн Номгон жаргалант ӨЭМТ	1	318.0	-	-	1	318.0	-	-	-	-	-	-
12	Хан-Уул дүүргийн Нинж ундрага эх ӨЭМТ	1	25.6	-	-	-	-	1	25.6	-	-	-	-
13	Баянзүрх дүүргийн Өрнөх эрүүл жаргал ӨЭМТ	1	274.6	-	-	1	274.6	-	-	-	-	-	-
14	Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ	1	33.3	-	-	-	-	1	33.3	-	-	-	-
15	Баянзүрх дүүргийн Үүрийн мандах гэгээ ӨЭМТ	1	371.9	-	-	1	371.9	-	-	-	-	-	-
16	Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ	1	83.0	-	-	-	-	1	83.0	-	-	-	-
17	Баянгол дүүргийн Ангирмаа ӨЭМТ	1	35.3	-	-	-	-	1	35.3	-	-	-	-
18	Баянгол дүүргийн Ашид амгалан ӨЭМТ	1	38.2	-	-	-	-	1	38.2	-	-	-	-
19	Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ	1	61.7	-	-	-	-	1	61.7	-	-	-	-
20	Баянгол дүүргийн Усантүрүү ӨЭМТ	1	6.3	-	-	-	-	1	6.3	-	-	-	-
21	Баянгол дүүргийн Чин гэгээ ӨЭМТ	1	13.4	-	-	-	-	1	13.4	-	-	-	-
22	Баянгол дүүргийн Эрхэмжаргалан ӨЭМТ	1	63.6	-	-	-	-	1	63.6	-	-	-	-
23	Сүхбаатар дүүргийн Ачит гар ӨЭМТ	1	26.6	-	-	-	-	1	26.6	-	-	-	-
24	Сүхбаатар дүүргийн Гэрэлт манал ӨЭМТ	1	126.5	-	-	-	-	1	126.5	-	-	-	-
25	Сүхбаатар дүүргийн Өнөр өрх ӨЭМТ	1	49.8	-	-	-	-	1	49.8	-	-	-	-
26	Сүхбаатар дүүргийн Өөдрөг-Энх ӨЭМТ	1	496.1	-	-	1	496.1	-	-	-	-	-	-
27	Сүхбаатар дүүргийн Тэгшмэнд ӨЭМТ	1	14.6	-	-	-	-	1	14.6	-	-	-	-
28	Сүхбаатар дүүргийн Увидаст -Од ӨЭМТ	1	90.4	-	-	-	-	1	90.4	-	-	-	-
29	Сүхбаатар дүүргийн Энхийн санаа ӨЭМТ	1	17.0	-	-	-	-	1	17.0	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

30	Сүхбаатар дүүргийн Сайннараран ӨЭМТ	1	6.3	-	-	-	-	1	6.3	-	-	-	-	-
Дүн		30	3,254.35	-	-	6	2,265.1	24	989.3	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой														
1	Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй ӨЭМТ	1	36.3	-	-	1	36.3	-	-	-	-	-	-	-
2	Баянзүрх дүүргийн Андсайхан ӨЭМТ	2	43.5	-	-	2	43.5	-	-	-	-	-	-	-
3	Баянзүрх дүүргийн Ачитсайхан ӨЭМТ	2	51.9	1	0.5	1	51.4	-	-	-	-	-	-	-
4	Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ	4	51.9	1	0.4	3	51.6	-	-	-	-	-	-	-
5	Баянзүрх дүүргийн Евро-эм ӨЭМТ	2	56.2	1	4.6	1	51.6	-	-	-	-	-	-	-
6	Баянзүрх дүүргийн Ерөөл буян оршихуй ӨЭМТ	1	21.1	-	-	1	21.1	-	-	-	-	-	-	-
7	Баянзүрх дүүргийн Мараната ӨЭМТ	1	45.4	-	-	1	45.4	-	-	-	-	-	-	-
8	Баянзүрх дүүргийн Миний зөвлөгч ӨЭМТ	2	46.9	1	1.1	1	45.8	-	-	-	-	-	-	-
9	Баянзүрх дүүргийн Насан-Урт ӨЭМТ	2	148.1	1	0.7	1	147.5	-	-	-	-	-	-	-
10	Баянзүрх дүүргийн Нэмүүлэн ӨЭМТ	1	44.4	-	-	1	44.4	-	-	-	-	-	-	-
11	Баянзүрх дүүргийн Оцело сэргэлт ӨЭМТ	1	98.5	-	-	1	98.5	-	-	-	-	-	-	-
12	Баянзүрх дүүргийн Оч манал ӨЭМТ	3	18.4	-	-	-	18.4	1.0	-	-	-	-	-	-
13	Баянзүрх дүүргийн Өнөр Энхмэнд ӨЭМТ	2	82.6	-	-	1	63.1	1.0	19.5	-	-	-	-	-
14	Баянзүрх дүүргийн Сувилахуй ӨЭМТ	3	52.9	1	0.4	1	44.0	1.0	8.5	-	-	-	-	-
15	Баянзүрх дүүргийн Тэгш дүүрэн хүслэн ӨЭМТ	1	101.1	-	-	1	101.1	-	-	-	-	-	-	-
16	Баянзүрх дүүргийн Хасаг Эрдэнэ ӨЭМТ	1	54.5	-	-	1	54.5	-	-	-	-	-	-	-
17	Баянзүрх дүүргийн Хүн төвт ӨЭМТ	2	45.6	1	0.5	1	45.1	-	-	-	-	-	-	-
18	Баянзүрх дүүргийн Цэн оюу ӨЭМТ	1	49.7	-	-	1	49.7	-	-	-	-	-	-	-
19	Баянзүрх дүүргийн Эмнэхүй ӨЭМТ	3	15.8	-	-	-	-	3.0	15.8	-	-	-	-	-
20	Баянзүрх дүүргийн Энх Энэрэл ӨЭМТ	3	5.9	-	-	1	5.9	2.0	-	-	-	-	-	-
21	Баянзүрх дүүргийн Энх-Агшин ӨЭМТ	2	31.8	-	-	2	31.8	-	-	-	-	-	-	-
22	Баянзүрх дүүргийн Эрүүл оршихуй ӨЭМТ	3	11.8	-	-	-	-	3.0	11.8	-	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	Баянзүрх дүүргийн Эрүүл Өсөх ӨЭМТ	4	54.0	-	-	2	22.4	2.0	31.6	-	-	-	-	-
24	Хан-Уул дүүргийн Амгалан оргил өрх ӨЭМТ	3	91.9	-	-	1	20.9	2.0	71.1	-	-	-	-	-
25	Хан-Уул дүүргийн Амин-тус ӨЭМТ	2	38.0	-	-	-	-	2.0	38.0	-	-	-	-	-
26	Хан-Уул дүүргийн Аяут ӨЭМТ	3	67.2	-	-	-	-	3.0	67.2	-	-	-	-	-
27	Хан-Уул дүүргийн Нинж ундрага эх ӨЭМТ	4	36.0	-	-	-	-	4.0	36.0	-	-	-	-	-
28	Хан-Уул дүүргийн Степпе хэйлт ӨЭМТ	1	0.4	-	-	-	-	1.0	0.4	-	-	-	-	-
29	Хан-Уул дүүргийн Тэрмэстий ӨЭМТ	3	141.1	-	-	-	-	3.0	141.1	-	-	-	-	-
30	Хан-Уул дүүргийн Уясах ӨЭМТ	2	6.0	-	-	-	-	2.0	6.0	-	-	-	-	-
31	Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ	3	162.3	-	-	-	-	3.0	162.3	-	-	-	-	-
32	Хан-Уул дүүргийн Энхбуянт манал ӨЭМТ	3	40.6	-	-	-	-	3.0	40.6	-	-	-	-	-
33	Хан-Уул дүүргийн Эрдэнэ энхсаран ӨЭМТ	3	192.4	-	-	-	-	3.0	192.4	-	-	-	-	-
34	Сонгинохайрхан дүүргийн Гурванжаргал хайрхан ӨЭМТ	1	117.7	-	-	1.0	117.7	-	-	-	-	-	-	-
35	Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ	1	24.2	-	-	-	-	1.0	24.2	-	-	-	-	-
36	Баянгол дүүргийн Ариун чанар ӨЭМТ	1	-	-	-	-	-	1.0	-	-	-	-	-	-
37	Баянгол дүүргийн Ашид амгалан ӨЭМТ	1	1.8	-	-	1.0	1.8	-	-	-	-	-	-	-
38	Баянгол дүүргийн Манай эмнэлэг ӨЭМТ	1	-	-	-	-	-	1.0	-	-	-	-	-	-
39	Баянгол дүүргийн Сайн чагнуур ӨЭМТ	2	-	-	-	-	-	2.0	-	-	-	-	-	-
40	Баянгол дүүргийн Учрахуй ӨЭМТ	2	-	-	-	-	-	2.0	-	-	-	-	-	-
41	Баянгол дүүргийн Хаппи доктор ӨЭМТ	2	-	-	-	-	-	2.0	-	-	-	-	-	-
42	Сүхбаатар дүүргийн Ачит гар ӨЭМТ	2	61.6	-	-	-	-	2.0	61.6	-	-	-	-	-
43	Сүхбаатар дүүргийн Гэрэлт манал ӨЭМТ	1	6.2	-	-	-	-	1.0	6.2	-	-	-	-	-
44	Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ	1	8.9	-	-	-	-	1.0	8.9	-	-	-	-	-
45	Сүхбаатар дүүргийн Өнөр өрх ӨЭМТ	2	81.8	-	-	-	-	2.0	81.8	-	-	-	-	-

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

46	Сүхбаатар дүүргийн Тэгшмэнд ӨЭМТ	1	23.6	-	-	-	-	1.0	23.6	-	-	-	-	-
47	Сүхбаатар дүүргийн Увидаст -Од ӨЭМТ	1	19.9	-	-	-	-	1.0	19.9	-	-	-	-	-
48	Сүхбаатар дүүргийн Энхийн санаа ӨЭМТ	2	157.7	-	-	-	-	2.0	157.7	-	-	-	-	-
49	Сүхбаатар дүүргийн Энэр-Ази ӨЭМТ	2	64.8	-	-	-	-	2.0	64.8	-	-	-	-	-
50	Дундговь аймгийн Өлзийт мандал ӨЭМТ	1	2.8	-	-	1.0	2.8		-	-	-	-	-	-
51	Өвөрхангай аймгийн Хархорин-Энэрэл ӨЭМТөв	1	51.9	-	-	1.0	51.9		-	-	-	-	-	-
52	Баянхонгор аймгийн Оточ номгон ӨЭМТ	1	6.0	-	-	1.0	6.0		-	-	-	-	-	-
Дүн		100	2,573.2	7	8.1	33	1,274.2	60	1,290.9	-	-	-	-	-
Нийт дүн		130	5,827.6	7	8.1	39	3,539.3	84	2,280.2	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 231/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЄЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барьцаа дансны үлдэгдэлд бүртгэлтэй 2018-2023 онд хэрэгжиж дууссан хавсралтад дурдсан 25 ажлын 67,454,498.00 /жаран долоо сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн найм/ төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд буцаан олгоогүй байна. /Хавсралт №1/

Энэ нь, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өмнөх онуудад хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын барьцааны үлдэгдэл 67,454,498.00 /жаран долоон сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн найм/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/, нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0424_SAG-5.Docx

1526200369



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1314/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын харьяа Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн 15 эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл байгуулахаас, 8 эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх зорилттой нийцээгүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23-т "Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн олон нийтийг төлөөлөх гурван гишүүнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар нээлттэй сонгон шалгаруулна", 15.30-д "Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг аймаг, дүүргийн Засаг дарга шууд батламжилна", Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгийн бие даасан байдлыг хэрэгжүүлэх заавар"-ын 1-д "Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-д эмнэлгийн засаглах эрхийг шилжүүлэх замаар шийдвэр гаргалт, тусламж үйлчилгээнд тавих хяналт, үйл ажиллагааны зохицуулалтад өмчлөгч болон санхүүжүүлэгч байгууллага, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн төлөөллийг оролцох боломжийг бүрдүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shoardlaga\2026\0424\SAГ-17.Docx

1526182122

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох эрх зүйн орчинд нийцүүлэн ТУЗ байгуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1315/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЄЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжээс тавих хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүү болон нийцлийн асуудлаар нийт 232,407,429,130.00 /хоёр зуун гучин хоёр тэрбум дөрвөн зуун долоон сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун гуч/ төгрөгийн зөрчил илэрснээс 948,611,510.00 /есөн зуун дөчин найман сая зургаан зуун арван нэгэн мянга таван зуун арав/ төгрөгийн зөрчилд 247 төлбөрийн акт тогтоож, 131,133,786,720.00 /нэг зуун гучин нэгэн тэрбум нэг зуун гучин гурван сая долоон зуун наян зургаан мянга долоон зуун хорь/ төгрөгийн зөрчилд 534 албан шаардлага хүргүүлж, 47,163,220,210.00 /дөчин долоон тэрбум нэг зуун жаран гурван сая хоёр зуун хорин мянга хоёр зуун арав/ төгрөгийн зөрчилд 665 зөвлөмж өгч, 51,965,272,690.00 /тавин нэгэн тэрбум есөн зуун жаран таван сая хоёр зуун далан хоёр мянга зургаан зуун ер/ төгрөгийн зөрчилд 55 хариуцлага тооцох албан шаардлага өгч, 1,196,537,000.00 /нэг тэрбум нэг зуун ерэн зургаан сая таван гучин долоон мянга/ төгрөгийн 4 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1316/АӨ111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн бараа материалын дансанд үлдэгдэлээр бүртгэсэн 16.650,088.00 /арван зургаан сая зургаан зуун тавин мянга наян найм/ төгрөгийн 4 ширхэг хөрөнгийг Космостек монгол ХХК-аас, 1,044,546,250.00 /нэг тэрбум дөчин дөрвөн сая таван зуун дөчин зургаан сая хоёр зуун тавь/ төгрөгийн 81 ширхэг тоног төхөөрөмжийг Ай эм эс инженеринг ХХК-с биетээр хүлээж аваагүй, бэлтгэн нийлүүлэгч компанитай хадгалалтын гэрээ байгуулаагүй, агуулахад нь хадгалуулж байгаагаар жилийн эцэст тооцоо нийлсэн нь төсвийн хөрөнгө дутагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Бэлтгэн нийлүүлэгч, байгууллагаас хөрөнгийг хүлээж аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1317/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЄЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан, нийт 1,531,137,642.00 /нэг тэрбум таван зуун гучин нэгэн сая нэг зуун гучин долоон мянга зургаан зуун дөчин хоёр/ төгрөгийн өртөгтэй 3 барилга байгууламжийг ашиглагч байгууллагад хууль тогтоомжийн дагуу шилжүүлээгүй, бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.4.6-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-н 4.5-д "Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусах хүртэл захиалагч байгууллага нь "бусад эргэлтийн хөрөнгө" дансанд бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн барилгыг ашиглагч байгууллагын данс бүртгэлд шилжүүлэх талаар арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1318/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЄЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын А/139 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн яамны төсвийн шууд захирагчид эрх шилжүүлэн, Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан сувилагч нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахад зориулж 300,000,000.00 /гурван зуун сая/ төгрөгийн санхүүжилтийг олгохдоо батлагдсан төсвөөс 23,363,460.00 /хорин гурван сая гурван зуун жаран гурван мянга дөрвөн зуун жар/ төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалт, 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж тус тус заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Батлагдсан төсвөөс илүү зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

СМАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тогруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban.Shaardlaga\2026\0424.SAG-17.Docx

1526182114



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1319 /АД11371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт арга хэмжээний зардлаас Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/92 дугаар тушаалаар Улсын нэгдүгээр төв эмнэлэгт эрх шилжүүлэн "Эмчээ сонсьё, Сувилагч, эх баригчаа сонсьё" арга хэмжээнд зориулж 80,000,000.00 /наян сая/ төгрөг, А/526 дугаар тушаалаар суурин компьютер худалдан авахад зориулж 16,020,000.00 /арван зургаан сая хорин мянга/ төгрөг, нийт 96,020,000.00 /ерэн зургаан сая хорин мянга/ төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн зориулалт бусаар зарцуулсан" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-17.Docx

1526182112



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1320/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/33/НА-СТА-ТЄЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,683,342,490.00 /арван хоёр тэрбум зургаан наян гурван сая гурван зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун ер/ төгрөгийн зөрчил илэрснээс 435,120,650.00 /дөрвөн зуун гучин таван сая нэг зуун хорин мянга зургаан зуун тавь/ төгрөгийн зөрчилд 127 төлбөрийн акт тогтоож, 7,793,859,870.00 /долоон тэрбум долоон зуун ерэн гурван сая найман зуун тавин есөн мянга найман зуун дал/ төгрөгийн зөрчилд 187 албан шаардлага хүргүүлж, 4,121,602,970.00 /дөрвөн тэрбум нэг зуун хорин нэгэн сая зургаан зуун хоёр мянга есөн зуун дал/ төгрөгийн зөрчилд 373 зөвлөмж өгч, 332,759,000.00 /гурван зуун гучин хоёр сая долоон зуун тавин есөн мянга/ төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 4 албан шаардлага өгсөн бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвийн өмч нь орон нутагт хамаардаг, Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр болон хувьсах зардлаар санхүүжилт авдаг боловч Бүх гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэсэн өмчийн хэлбэртэй байгаагаас удирдлагын менежмент, санхүүгийн хяналтын тогтолцоо алдагдахад хүрсэн тул хууль, хяналт, эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 54.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна",

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.11-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах", 8.1.13-д "аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,683,342,490.0 төгрөгийн зөрчил илэрсэн, дотоод хяналтын тогтолцоо алдсан байгаа тул Өрхийн эрүүл мэндийн төвийн өмчийн хэлбэр, удирдлагын менежмент, эрх зүйн орчинг тодорхой болгож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /Э.Батшугар/, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Эрдэнэбаяр/, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга /Л.Мөнхцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН